

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны
06 дугаар сарын 11-ний өдрийн 225
дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны
бүртгэлийн журам"-ын 4 дугаар хавсралт

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/						
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>						
Тайлагнах хугацаа	2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр					
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Үнэт цаас гаргагчийн нэр: ХасБанк ХК УБГД: 9016001007 Үнэт цаасны симбол: ХАС Утасны дугаар: +976-75771888					
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ХК					
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүү					
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Эрнст энд Янг Монголия Аудит ХХК, бүртгүүлсэн огноо: 2013 оны 5 дугаар сарын 08					
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000					
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Г.Тамир /Санхүү удирдлага, олон улсын харилцааны газрын захирал/ Хянасан: Г.Эрдэнэбаяр /Санхүү хариуцсан захирал/ Хянасан: Н.Мөнхцэлмэг /Хууль хариуцсан захиал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/					
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан					
	<table border="1"> <tr> <td>Санхүүгийн байдлын үзүүлэлт</td> <td rowspan="4">2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав. /Хавсралт №1/</td> </tr> <tr> <td>Орлогын тайлан</td> </tr> <tr> <td>Өмчийн өөрчлөлтийн тайлан</td> </tr> <tr> <td>Мөнгөн гүйлгээний тайлан</td> </tr> </table>	Санхүүгийн байдлын үзүүлэлт	2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав. /Хавсралт №1/	Орлогын тайлан	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан
Санхүүгийн байдлын үзүүлэлт	2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав. /Хавсралт №1/					
Орлогын тайлан						
Өмчийн өөрчлөлтийн тайлан						
Мөнгөн гүйлгээний тайлан						
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт					

	2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн хараат бус аудитор хянах ажил хийгдэж байна.		
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт		
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<p>2024 оны 1-р хагас жилд ХасБанк ХК-ийн татварын дараах цэвэр ашиг 85.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх мөн үеэс 38.3%-р өсөж, өөрийн хөрөнгийн өгөөж (aROE) жилийн 26.6%, нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг (EPS) 81.0 төгрөгт хүрсэн байна. Банкны ашигт ажиллагаа тогтвортой нэмэгдэхэд активын өсөлт, балансын оновчтой бүтэц, активын чанар голлон нөлөө үзүүлж байна.</p> <p>Тайлант хугацаанд ХасБанк ХК-ийн нийт актив хөрөнгө 5,629.7 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс 10.0%-р өссөн. Үүнд: Иргэдийн зээлийн багц 23.0%-р өсөж 2,364.0 тэрбум, Байгууллагын зээлийн багц 15.6% өсөж 560.1 тэрбум төгрөг, Хаслизингийн багц 16.1%-р өсөж 398.1 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Иргэдийн банкны зээлийн багц өсөхөд бичил, жижиг бизнесийн зээлийг зах зээлд таниулах үйл ажиллагаа тогтмол хийгдэж байгаа нь голлон нөлөөлсөн бол Хаслизингийн багц нэмэгдэхэд дугаартай автомашины санхүүгийн түрээс болон хүнд даацын тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн өсөлт түлхүү нөлөөлсөн байна.</p> <p>Тайлант хугацаанд нийт зээл, санхүүгийн түрээсийн багцад эзлэх чанаргүй зээлийн харьцаа оны эхнээс 0.7 нэгж хувиар буурч 2.2%-д хүрсэн нь банкны системд тэргүүлэх үзүүлэлтүүдийн нэг юм.</p> <p>ХасБанк нь харилцагчдадаа бизнесийн болон хувийн дансаа шуурхай, найдвартай удирдахад зориулан харилцах дансны үйлчилгээг санал болгодог. Харин хадгаламжийн бүтээгдэхүүн энгийн хугацаагүй хадгаламжаас эхлээд хүүгээ сар бүр зарлагадах боломжтой хугацаатай хадгаламж, хүүхдэд зориулсан урт хугацаат хуримтлалын бүтээгдэхүүнүүдээс бүрддэг. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах цахим сувгийг нэмэгдүүлэхээс гадна хадгаламжийн бүтээгдэхүүний урамшуулалт аян зарлах зэрэг харилцагчдад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үр дүнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар банкны нийт харилцах, хадгаламжийн үлдэгдэл 11.3%-р өсөж 3,199.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд 104.3 сая ам.долларын урт хугацаатай эх үүсвэрийг EBRD, PROPARCO, DWM болон FMO зэрэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлэн ажиллалаа. Шинээр авсан эх үүсвэрийг эмэгтэй бизнес эрхлэгч болон эрчим хүчний хэмнэлт бүхий бизнесүүдийг дэмжихэд зориулна.</p>	
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Монголбанкнаас тогтоосон байвал зохих хэмжээ	ХасБанкны 2024-06-30-ны байдлаарх үзүүлэлт
	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>12.5%	18.6%

		Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	18.6%
		Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>25%	38.7%
		Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	+/- 15%	-2.3%
		Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар)	+/- 30%	-3.3%
		Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа	<300%	52.9%
		Том 10 харилцагчийн хадгаламж, харилцахын төвлөрлийн харьцаа	<25%	7.9%
3.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>Гадаад хүчин зүйлс: Монгол улсын эдийн засаг 2024 оны 1-р улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 хувиар өсөхөд уул уурхайн салбар 1.9 нэгж, тээвэр болон үйлчилгээний салбар тус бүр 1.3 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн бол худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, барилга зэрэг салбаруудад нийт өсөлтийн 1.3 нэгж хувь ногдож байна. Харин зудын хүндрэлээс шалтгаалан хөдөө аж ахуйн салбар үргэлжлэн агшиж, улмаар эдийн засгийн өсөлтийг хумих чиглэлд 1.3 нэгж хувиар нөлөөлсөн байна. Эдийн засгийн өсөлтийн ¼-г уул уурхайн салбар дангаар бүрдүүлсэн бөгөөд тэр дундаа нүүрсний экспорт голлон өсөлтийг бүрдүүлсэн байна. Эдийн засгийн бодит өсөлт нь банкны салбарын активын тэлэлтийг нэмэгдүүлж, зах зээлд зээлийн бүтээгдэхүүний өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна. Мөн эдийн засгийн өсөлт нь банкны салбарын активын чанарын үзүүлэлтэд эергээр нөлөөлж байна.</p> <p>Инфляцын түвшин аажмаар буурч энэ оны 6-р сарын байдлаар улсын хэмжээнд 5.1%, Улаанбаатар хотод 4.8%-д хүрч Монголбанкны инфляцын зорилт болох 6±2 хувийн түвшинд хадгалагдсан хэвээр байна. Импортын бараа бүтээгдэхүүний инфляцад үзүүлэх нөлөө буурч, дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнэ тогтворжих хандлагатай байгаа нь инфляцын түвшин буурахад гол нөлөөг үзүүлсэн байна. Улмаар Мөнгөний бодлогын хороо 2024 он гарснаас хойш гурван удаа хуралдаж бодлогын хүүг нийт 2 нэгж хувиар бууруулан 11%-д хүргээд байна. Бодлогын хүү өөрчлөгдөхөд тухайн банкны актив, пассивын бүтцээс хамааран цэвэр хүүгийн орлогод тодорхой хугацааны хоцрогдолтойгоор нөлөө үзүүлдэг.</p> <p>2024 оны эхний 6 сарын байдлаар нийт экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4%-р өсөж 7.9 тэрбум ам.долларт, нийт импорт 26%-р өсөж 5.4 тэрбум ам.долларт хүрснээр гадаад худалдааны тэнцэл 2.5 тэрбум ам.долларын ашигтай гарсан. Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 5 сарын байдлаар 351 сая ам.долларын ашигтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 152 сая ам.доллараар буурсан үзүүлэлт болж байна. Гадаад валютын албан нөөц (ГВАН) 2024 оны 6-р сард 4.8 тэрбум ам. долларт хүрч оны эхнээс 1.7%-р буурсан байна. Цэвэр</p>		

		<p>экспорт тогтвортой ашигтай байгаа, мөн төлбөрийн тэнцэл эерэг байгаа зэргээс шалтгаалан төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтвортой байгаа нь банкны салбарт долларжилт нэмэгдэх нөхцөлийг бууруулж, улмаар банкуудын төгрөгийн ликвидитид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж байна.</p> <p>Дотоод хүчин зүйлс: 2024 онд ХасБанк эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн хүүг бууруулахаас гадна бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд банкны бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг дэлгэрэнгүй танилцуулж бизнес эрхлэгчидтэй харилцаа тогтоох зорилготой бизнес уулзалтуудыг Улаанбаатар хотын томоохон худалдааны төвүүдэд болон зарим аймгуудад зохион байгуулж 9 удаагийн уулзалтаар 500 гаруй бизнес эрхлэгчид оролцлоо.</p> <p>Тайлант хугацаанд Рио Тинто Монгол ХХК, МАК ХХК зэрэг үндэсний томоохон ААН-уудтай урт хугацаат хуримтлалын дансны бүтээгдэхүүнээр хамтран ажиллах гэрээг амжилттай байгуулан ажиллаж байна.</p> <p>ХасБанк НҮБ-ын дэргэдэх Уур Амьсгалын Ногоон Сангийн санхүүжилттэй хэрэгжүүлдэг “Хүлэмжийн хийг буруулах бизнесийн зээл” төслийн хүрээнд Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг үйл ажиллагаагаа өргөжүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, улмаар экспортод бараа бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд нь бодит тусалцаа үзүүлэх зорилгоор “Жижиг, дунд бизнесүүдэд ISO стандарт нэвтрүүлэх хөтөлбөр”-ийг зарласан. Тус хөтөлбөрийн хүрээнд нийт 100 гаруй ААН-үүдээс 16 ААН-ийг шалгаруулж ISO стандарт нэвтрүүлэхэд шаардагдах зөвлөх үйлчилгээ болон баталгаажуулалтын зардлын 80%-ийг ХасБанкнаас санхүүжүүлэх батламжаа хүлээн авлаа.</p> <p>Төлбөр тооцоо, зээл, санхүүгийн түрээс, хадгаламж, биет алтны арилжаа гэх мэт банкны цогц үйлчилгээг тав тухтай найдвартай орчинд түргэн шуурхай үзүүлэх зорилго бүхий Премиум салбар нь 2024 оны 4 сарын 18-нд нээлтээ хийлээ.</p> <p>Байгалд ээлтэй Эко автомашины хөнгөлөлттэй нөхцөл бүхий лизингийн үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор Dongfeng брэндийн албан ёсны борлуулагч Мершип ХХК, IM брэндийн албан ёсны борлуулагч Электрик Моторс Корпорайшн ХХК-тай хамтын ажиллагааг эхлүүлээ.</p>
3.4.	<p><i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i></p>	<p>ХасБанкны тэнцлийн гадуурх дансны үлдэгдлийн тайланг хавсаргав /Хавсралт № 2/</p>

4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>										
	<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нээлттэй хувьцаат компани болсноос хойш холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд мэдээлдэг. Дараах холбоосоор орж танилцана уу.</p> <p>https://www.xacbank.mn/page/conflict-of-interest-transaction https://mse.mn/mn/company/568</p> <p>Түүнчлэн, Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайланг улирал бүр гарган өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг. Тус тайлантай дараах холбоосоор орж танилцана уу.</p> <p>https://www.xacbank.mn/page/the-loans-and-other-equivalent-assets-provided-to-the-related-parties</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2024 оны эхний хагас жилд нийт 6 сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийг баталсан. Ингэхдээ, Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг баримталсан.</p> <p>Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.</p>										
5.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</p>										
	<p>Тайлант хугацаанд нэмэлт хувьцаа гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлээгүй болно.</p>										
6..	<p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p>										
	<p>Хувьцаа эзэмшлийн бүтэц Тайлангийн өдрийн байдлаар ХасБанкны хувьцаа эзэмшигчид дараах бүтэцтэй байна:</p> <table border="1" data-bbox="251 1270 1144 1543"> <tr> <td> 19.37%</td> <td> 16.63%</td> <td> 16.28%</td> <td> 12.50%</td> <td> 10.18%</td> </tr> <tr> <td> 9.83%</td> <td> 6.42%</td> <td> 3.61%</td> <td>М. Болдоо 0.10%</td> <td>Ч. Ганболд 0.09%</td> </tr> </table> <div data-bbox="1250 1270 1502 1543" style="border: 1px solid gray; padding: 5px; text-align: center;"> <p>ОЛОН НИЙТ (IPO)</p> </div> <div data-bbox="251 1585 511 1690" style="border: 1px solid gray; padding: 5px; margin-top: 10px;">  <p>ТЭНГЭР САНХҮҮГИЙН НЭГДЭЛ</p> </div> <p data-bbox="535 1596 868 1669">* Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ХасБанк дахь шууд бус хувь эзэмшил</p> <div data-bbox="324 1722 430 1774" style="border: 1px solid gray; border-radius: 50%; padding: 5px; text-align: center;">94.99%</div> <div data-bbox="690 1690 1047 1795" style="border: 1px solid gray; padding: 10px; text-align: center; margin: 10px auto; width: fit-content;">  </div> <div data-bbox="1323 1722 1429 1774" style="border: 1px solid gray; border-radius: 50%; padding: 5px; text-align: center;">5.01%</div>	 19.37%	 16.63%	 16.28%	 12.50%	 10.18%	 9.83%	 6.42%	 3.61%	М. Болдоо 0.10%	Ч. Ганболд 0.09%
 19.37%	 16.63%	 16.28%	 12.50%	 10.18%							
 9.83%	 6.42%	 3.61%	М. Болдоо 0.10%	Ч. Ганболд 0.09%							

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүн

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах гишүүдийг 2 жилийн хугацаатай томилсон:

№	Овог нэр	Гишүүнчлэл	Банкинд эзэмшиж буй хувьцааны хувь
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн дарга	0.08%
2	Албертус Браггинк	ТУЗ-ийн гишүүн	-
3	Анджей Витак	ТУЗ-ийн гишүүн	-
4	Доминик Жак	ТУЗ-ийн гишүүн	-
5	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	-
6	Сюзанна Карр	ТУЗ-ийн гишүүн	-
7	Г.Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн	0.10%
8	Н.Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	-
9	Нираж Вэдва	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
10	Стюарт Холл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
11	Б.Уламбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
12	Эми Чой	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн

№	Аудитын хороо	Эрсдэлийн удирдлагын хороо	Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо
Дарга	Б.Уламбаяр	Албертус Браггинк	Майкл Мадден
Гишүүд	Нираж Вэдва	Б.Уламбаяр	Н.Цэлмүүн
	Эми Чой	Нираж Вэдва	Б.Уламбаяр
	Анджей Витак	Эми Чой	Нираж Вэдва
	Сюзанна Карр	Стюарт Холл	Эми Чой
	Стюарт Холл	Доминик Жак	Стюарт Холл

Гүйцэтгэх удирдлагын баг

№	Овог нэр	Албан тушаал	Банкинд эзэмшиж буй хувьцааны хувь
1	Г.Цэвэгжав	Гүйцэтгэх захирал	0.10%
2	Г.Эрдэнэбаяр	Санхүү хариуцсан захирал	0.08%
3	Э.Уламбаяр	Иргэдийн банк хариуцсан захирал	0.05%
4	Б.Еркин	Байгууллагын банк хариуцсан захирал	0.04%
5	С.Дауренбек	Лизинг хариуцсан захирал	0.04%
6	Ж.Мөнхсайхан	Бизнес хөгжил хариуцсан захирал	0.02%
7	Илия Аврамов	Эрсдэл хариуцсан захирал	0.00%
8	Г.Зул	Үйл ажиллагаа хариуцсан захирал	0.04%
9	Х.Өнөрбат	Мэдээллийн технологи хариуцсан захирал	0.03%
10	Э.Ундармаа	Ерөнхий аудитор	0.03%
11	Н.Мөнхцэлмэг	Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	0.01%

7.

Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ХасБанк нь хувьцаат компани болсноос хойш Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекст заасны дагуу түүний 2023 оны хэрэгжилтийн үнэлгээний тайланг бэлтгэн гаргасан бөгөөд тус тайланг Монголын хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлсэн. Дараах холбоосоор орж танилцана уу.

<https://mse.mn/mn/company/568>

<https://xacbank.mn/page/financial-operational-result>

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

ХасБанк хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсанаас хойших хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Шангри-Ла зочид буудлын их танхимд цахим болон танхим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулагдсан. Хурлын ирц 95.88%-ийн ирцтэйгээр хүчин төгөлдөр бүрдэж, дараах 10 асуудлыг хэлэлцэн баталсан болно:

1. ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн хамт баталсан;
2. ХасБанкны 2023 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн хамт баталсан;
3. ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 26,580,675,000 төгрөг буюу нэгж хувьцаанд 25.25 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр зарлан хуваарилах шийдвэр гаргасан;
4. ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулсан;
5. ЕСБХБ болон ХасБанкны хооронд Фреймворк гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон;
6. ОУСК болон ХасБанкны хооронд Бодлогын гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон;
7. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн;
8. ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгосон;
9. ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хөлсийг шинэчлэн тогтоосон; мөн
10. ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг баталсан.

Эдгээр тогтоолуудтай Монголын хөрөнгийн бирж болон ХасБанкны цахим хуудсаар дамжуулан танилцана уу. <https://xacbank.mn/page/shareholders-meeting-resolution>

Ийнхүү ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан, хувьцаа эзэмшигч тухайн өөрчлөн байгуулах асуудлаар эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй тохиолдолд, Компанийн тухай хуулийн 24.1 болон 53.1 дэх хэсэгт заасныг үндэслэн өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг ХасБанкнаас шаардах эрхтэй талаар мөн хуулийн 54 дүгээр зүйлийн дагуу өдөр тутмын сонин, Монголын хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсэн. Шаардах эрхийг хэрэгжүүлэх хугацаа 2024 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд уг хугацаанд шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлт ирээгүй болно. Зартай дараах холбоосоор орж танилцана уу.

<https://xacbank.mn/article/huvitsaa-erguulen-hudaldan-avahiig-shaardah-erh>

<https://mse.mn/mn/news/12215>

2. Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") болон ТУЗ-ийн дэргэдэх хорооны хурал

Банкны ТУЗ нь 2024 оны эхний хагас жилд 2 удаагийн ээлжит хурлыг оролцуулан нийт 4 удаа хуралдаж, 11 удаа цахимаар санал хураан, нийт 32 тогтоол шийдвэрийг гаргаж ажилласан байна. ТУЗ-ийн ээлжит хурал тус бүрээр ТУЗ-ийн хурлын өмнөх шийдвэр, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаарх мэдээллийг ТУЗ-д танилцуулдаг.

2024 оны эхний хагас жилд ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын

хороо 3 удаа хуралдаж, 4 удаа цахимаар санал хураан, Эрсдэлийн удирдлагын хороо 3 удаа хуралдаж, 8 удаа цахимаар санал хураан, Аудитын хороо 3 удаа хуралдаж, ТУЗ-д холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна.

3. ТУЗ-ийн үйл ажиллагаа:

Компанийн тухай хуульд заасан хувьцаат компанийн тусгай зохицуулалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн актууд, Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцүүлэн ХасБанкны ТУЗ-өөс 2024 оны эхний хагас жилд дараах журам, төлөвлөгөө, хөтөлбөрийг шинээр баталж, нэмэлт өөрчлөлт оруулж болон шинэчлэн баталсан. Үүнд:

Шинээр баталсан:

1. Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын 2023-2025 оны шилжилтийн төлөвлөгөө – ХасБанкны үйл ажиллагааг Парисын хэлэлцээрт тусгасан зорилтуудад уялдуулах шилжилтийг дэмжих, олон улсын сайн жишигт нийцүүлэх үүднээс энэхүү удирдлага төлөвлөлтийн бичиг баримтыг баталсан;
2. Хувьцааг эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журам – Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх замаар ХасБанкийг өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан ТУЗ нь хувьцааг эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг Компанийн тухай хуульд заасанд нийцүүлэн баталсан. Энэхүү журмын үйлчлэл зөвхөн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх замаар ХасБанкийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан шаардах эрх хэрэгжүүлэх харилцаагаар хязгаарлагдана. Тус журмын дагуу тус ажиллагааг амжилттай зохион байгуулсан болно.
3. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах ерөнхий журам – ХасБанкны засаглалын төлөвлөгөө 2023-2026-д тусгасны дагуу, Банкны тогтвортой өсөлтийг хангах, урт хугацаанд үнэ цэнийг бий болгоход чухал үүрэг бүхий оролцогч талуудтай үр дүнтэй харилцах, хамтран ажиллахад баримтлах үндсэн шаардлагуудыг тодорхойлох зорилгоор энэхүү журмыг баталсан;
4. ТУЗ-ийн 2024 оны сургалтын хөтөлбөр – ХасБанкны засаглалын төлөвлөгөө 2023-2026-д тусгасны дагуу, Банкны стратегийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийн холбогдох ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх үүднээс 2024 оны сургалтын хөтөлбөрийг баталсан;
5. ТУЗ-ийн үнэлгээний дараах 2024 оны ажлын төлөвлөгөө – ТУЗ өөрийн 2023 оны үнэлгээний үр дүнг хэлэлцэж, уг үнэлгээний дагуу 2024 онд хийж гүйцэтгэх ажлуудын төлөвлөгөөг баталсан.

Нэмэлт өөрчлөлт оруулсан:

1. Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны ерөнхий журам – ХасБанкны засаглал, хууль тогтоомжийн нийцлийг бэхжүүлэх үүднээс тодорхой нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.

Шинэчлэн баталсан:

1. ТУЗ-ийн үнэлгээний ерөнхий журам.
2. Мөн ТУЗ нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах үүднээс ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шинэчлэн батлуулсан.
3. Ёс зүйн кодекс, сонирхлын зөрчил ба толилуулга
ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан, ёс зүйд тулгуурласан зан суртахууны соёлыг төлөвшүүлэх зорилгоор 2023 онд “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ыг баталж, үйл ажиллагаандаа

хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХасБанк нь өөрийн ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлөөр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх, улмаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор “Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам”-ыг 2023 онд баталсан бөгөөд энэ талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр Монголын хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлж байна.

4. Банкны оролцогч талуудтай харилцах харилцаа

ХасБанк нь холбогдох дотоод журмын дагуу хувьцаа эзэмшигчтэй тусгай дугаар (+976-8508-1888) болон цахим шуудан (investor-relations@xacbank.mn)-гаар харилцан ажиллаж байна. Мөн Банкны тогтвортой өсөлтийг хангах, урт хугацаанд үнэ цэнийг бий болгоход чухал үүрэг бүхий оролцогч талуудтай үр дүнтэй харилцах, хамтран ажиллахад баримтлах үндсэн шаардлагуудыг тодорхойлох зорилгоор Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах ерөнхий журмыг баталсан бөгөөд өөрийн xacbank.mn цахим хуудсаар дамжуулан тэдэнд мэдээллийг тогтмол хүргэж байна.

5. Мэдээллийн ил тод байдал

ХасБанк нь өөрийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад банкны талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу ил тод тайлагнан, мэдээлэх зорилгоор “Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам”-ыг 2023 онд баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж буй бөгөөд ТУЗ нь түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Холбогдох мэдээлэлтэй Монголын хөрөнгийн бирж болон ХасБанкны цахим хуудсаар дамжуулан танилцах бүрэн боломжтой.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Цэвэгжав

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Эрдэнэбаяр

Албан тушаал: Санхүү хариуцсан захирал

Гарын үсэг:

Овог, нэр: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Мэдээлэл бэлтгэн, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Тамир

Албан тушаал: Санхүү удирдлага олон улсын харилцааны газрын захирал

Гарын үсэг:

2024 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

Д/д	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн /2023.12.31/	Тайлант үеийн /2024.06.30/
1	Хүүгийн орлого	534,681,934,898.43	338,301,768,518.83
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	18,493,666,754.83	7,584,900,096.55
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	2,043,397,174.31	2,466,586,195.82
1.3	Үнэт цаасны	108,166,769,987.52	71,739,692,942.20
1.4	Зээлийн	398,094,295,060.12	252,826,639,391.43
1.5	Бусад хүүгийн орлого	7,883,805,921.65	3,683,949,892.83
2	Хүүгийн зардал	284,186,728,864.60	191,085,885,711.21
2.1	Харилцахад төлсөн хүү	2,048,818,003.17	2,029,577,643.85
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	160,471,736,723.62	102,921,362,949.13
2.3	Зээлийн хүүгийн зардал	90,525,572,173.73	53,417,308,775.00
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	755,740,806.45	434,038,568.75
2.5	Бусад хүүгийн зардал	30,384,861,157.62	32,283,597,774.48
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	250,495,206,033.83	147,215,882,807.62
4	Эрсдэлийн сангийн зардал	189,605,187.53	45,257,504.18
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	27,810,398.73	45,257,504.18
4.2	Үнэт цаасны	161,794,788.80	-
4.3	Зээлийн	-	-
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	250,305,600,846.30	147,170,625,303.44
6	Бусад орлого	79,396,034,576.19	43,069,069,897.80
6.1	Хүүгийн бус орлого	75,156,652,836.71	41,833,747,835.99
6.1.1	Арилжааны орлого	9,883,302,313.05	7,404,615,751.69
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	-	-
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	50,216,255,097.62	28,687,891,031.89
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	15,057,095,426.04	5,741,241,052.41
6.2	Бусад орлого, олз	4,239,381,739.48	1,235,322,061.81
7	Бусад зардал	139,013,018,221.72	76,747,769,386.69
7.1	Хүүгийн бус зардал	132,746,382,073.29	75,425,630,056.55
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	138,076,004.05	-
7.1.2	Арилжааны зардал	-	-
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	1,367,843,716.12	2,419,967,128.26
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	13,984,689,156.22	8,332,015,709.52
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	117,255,773,196.89	64,673,647,218.77
7.2	Бусад зардал, гарз	6,266,636,148.43	1,322,139,330.14
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	190,688,617,200.78	113,491,925,814.55
9	Орлогын татварын зардал	48,629,972,339.20	28,182,551,801.06
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	142,058,644,861.58	85,309,374,013.49
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	142,058,644,861.58	85,309,374,013.49
13	Бусад дэлгэрэнгүй орлого	277,438,018.66	(750,610,303.51)
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	-	-
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	277,438,018.66	(750,610,303.51)
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт		
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт		
13.5	Бусад		
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)	142,336,082,880.23	84,558,763,709.98

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБАЯР

2024 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

	Балансын зүйл	Эцсийн үлдэгдэл /2023.12.31/	Эцсийн үлдэгдэл /2024.06.30/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,798,147,992,594.32	1,646,712,715,508.43
1.1.1	Бэлэн мөнгө	67,977,909,064.34	35,846,877,369.33
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	681,381,802,075.26	648,856,848,572.80
1.1.3	Мөнгөгэй адилтгах хөрөнгө	1,046,019,649,335.77	960,398,470,537.78
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,768,632,118.95	1,610,519,028.51
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	239,378,374,785.05	293,545,692,341.32
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	239,748,124,782.71	293,703,977,105.93
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	-
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	-
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(369,749,997.66)	(158,284,764.61)
1.3	Хөрөнгө оруулалт	129,152,996,712.65	163,157,038,119.55
1.3.1	Арилжааны үнэт цаас	-	-
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	110,341,006,303.51	106,488,992,565.51
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	-	40,000,000,000.00
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	13,000,000,000.00	10,750,000,000.00
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,611,935,846.58	7,585,530,547.43
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	(2,799,945,437.44)	(1,667,484,993.39)
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	2,720,350,929,155.55	3,301,125,297,346.35
1.4.1	Хэвийн зээл	2,598,497,195,012.58	3,194,332,976,870.22
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	70,274,791,549.97	54,301,514,497.67
1.4.3	Хэвийн бус зээл	12,500,326,182.10	11,204,134,772.59
1.4.4	Эргэлзээтэй зээл	8,935,542,630.26	8,515,282,535.56
1.4.5	Муу зээл	59,542,875,356.97	54,363,827,410.91
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(12,626,372,320.92)	(15,808,175,113.93)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	45,712,172,337.38	53,194,944,977.35
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(62,485,601,592.79)	(58,979,208,604.02)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	56,800,917,709.73	47,363,005,020.14
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	29,432,407,965.53	28,945,595,075.98
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	29,432,407,965.53	28,945,595,075.98
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	-	-
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	-	-
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	59,821,906,730.31	62,348,478,489.35
1.7.1	Бусад тооцоо	29,682,244,268.86	33,656,742,429.96
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	2,598,458,154.79	2,518,511,264.37
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	94,439,362.68	94,439,362.68
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	9,443,968,093.99	8,281,550,974.14
1.7.5	Татварын авлага	25,631,356.00	25,608,116.00
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	8,870,068,127.59	7,850,542,444.78
1.7.7	Бусад	9,107,097,366.41	9,921,083,897.42
1.8	Үндсэн хөрөнгө	66,281,751,529.55	67,927,091,488.92
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	1,387,249,583.82	732,210,492.26
1.11	Биет бус хөрөнгө	18,667,114,054.76	17,794,844,692.24
	Нийт хөрөнгийн дүн	5,119,421,640,821.26	5,629,651,968,574.54
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	663,709,615,898.36	785,731,743,213.88
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	663,709,615,898.36	785,731,743,213.88
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	-	-
2.2	Хадгаламж	2,156,508,994,821.87	2,348,450,831,127.20
2.2.1	Хугацаагүй хадгаламж	170,993,684,035.36	201,633,616,286.02
2.2.2	Хугацаатай хадгаламж	1,959,803,296,756.07	2,119,341,794,935.25
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	13,088,144,288.41	12,974,404,078.45
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	12,623,869,742.02	14,501,015,827.48

	Балансын зүйл	Эцсийн үлдэгдэл /2023.12.31/	Эцсийн үлдэгдэл /2024.06.30/
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,297,532,571,172.34	1,602,922,447,838.99
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	79,443,211,983.04	89,649,947,517.33
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	1,211,903,841,708.19	1,508,421,411,687.19
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(10,590,809,897.39)	(12,065,694,731.80)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	16,776,327,378.50	16,916,783,366.28
2.4	Бусад эх үүсвэр	184,089,127,506.02	40,974,146,858.95
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	-	-
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	-	-
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	7,966,933,135.20	13,276,645,106.08
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	162,431,954,446.64	10,576,316,833.29
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	405,883,400.37	406,566,354.88
2.4.6	Бусад	13,264,265,143.65	16,464,969,970.17
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-	-
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	20,091,380.16	249,648,594.54
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	14,332,115,283.25	22,081,607,414.30
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	106,181,310,540.68	93,234,225,912.72
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	75,005,168,084.95	71,743,464,984.71
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
	Нийт өр төлбөрийн дүн	4,497,358,903,307.46	4,965,138,467,350.75
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	105,270,000,000.00	105,270,000,000.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	-
3.1.2	Энгийн хувьцаа	105,270,000,000.00	105,270,000,000.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	30,586,768,164.70	30,586,768,164.70
3.3	Халаасны хувьцаа	-	-
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	18,528,613,201.77	18,467,264,409.77
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	399,787,063,887.69	444,149,300,016.28
3.6	Бусад өөрийн хөрөнгө	67,890,292,259.64	66,040,168,633.04
3.6.1	Хувьцааны опцион	-	-
3.6.2	Нөөцийн сан	11,439,407,367.49	11,439,407,367.49
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	-	-
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	53,253,543,574.30	52,154,030,251.20
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-
3.6.6	Хөрвөх өр төлбөр	-	-
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	-	-
3.6.8	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	3,197,341,317.86	2,446,731,014.35
3.6.9	Хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан	-	-
3.6.10	Бусад	-	-
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	622,062,737,513.80	664,513,501,223.79
	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	5,119,421,640,821.26	5,629,651,968,574.54

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБЯАР

ХАСБАНКНЫ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны Зургаадугаар сар 30


Өөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	100,000,000,000.00	1,817,773,344.70	-	18,528,613,201.77	77,179,488,781.95	278,161,784,485.15	475,687,659,813.57
Нягтлан бодох бүртгэлийн болдлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							
Залруулсан үлдэгдэл	100,000,000,000.00	1,817,773,344.70	-	18,528,613,201.77	77,179,488,781.95	278,161,784,485.15	475,687,659,813.57
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал					277,438,018.66	142,058,644,861.58	277,438,018.66
Бусад дэлгэрэнгүй орлого					(9,566,634,540.96)	9,566,634,540.96	34,038,994,820.00
Өмчид гарсан өөрчлөлт	5,270,000,000.00	28,768,994,820.00				(30,000,000,000.00)	(30,000,000,000.00)
Хуваарилсан ногдол ашиг							
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							
2023 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	105,270,000,000.00	30,586,768,164.70	-	18,528,613,201.77	67,890,292,259.64	399,787,063,887.69	622,062,737,513.81
Нягтлан бодох бүртгэлийн болдлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							
Залруулсан үлдэгдэл	105,270,000,000.00	30,586,768,164.70	-	18,528,613,201.77	67,890,292,259.64	399,787,063,887.69	622,062,737,513.81
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал					(750,610,303.51)	85,309,374,013.49	85,309,374,013.49
Бусад дэлгэрэнгүй орлого					(1,099,513,323.10)	1,099,513,323.10	(750,610,303.51)
Өмчид гарсан өөрчлөлт						(42,108,000,000.00)	(42,108,000,000.00)
Хуваарилсан ногдол ашиг						61,348,792.00	61,348,792.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				(61,348,792.00)			
2024 оны 06-р сарын 30-ны өдрийн үлдэгдэл	105,270,000,000.00	30,586,768,164.70	-	18,467,264,409.77	66,040,168,633.04	444,149,300,016.28	664,513,501,223.79

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Г.НЭВЭГТЖАВ

Г.ЭРДЭНЭБЯАР



	Үзүүлэлт	Өмнөх үеийн /2023.12.31/	Тайлант үеийн /2024.06.30/
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	194,418,421,246.12	112,222,196,697.26
1.2	Орлого, зардлын тохируулга:	(252,480,122,859.05)	(146,744,714,146.93)
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	(15,102,577,047.73)	(5,048,787,874.04)
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	10,146,808,585.81	5,548,479,163.42
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	-	-
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(534,681,934,898.43)	(338,301,768,518.83)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	284,186,728,864.60	191,085,885,711.21
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	2,970,851,636.71	(28,522,628.69)
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	-	-
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	6,628,490,628.42	(457,699,985,910.09)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	16,338,808,226.98	(53,955,852,323.22)
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	-	-
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(680,810,825,679.69)	(570,595,266,191.51)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	35,800,593,188.14	10,064,973,906.22
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	2,615,867,361.58	(2,195,834,969.93)
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	445,671,582,170.33	312,086,817,535.40
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	104,070,253,111.79	(147,312,947,466.34)
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	68,377,283,373.51	(5,197,592,496.91)
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	14,564,928,875.78	(594,283,903.81)
1.4	Бусад тохируулга:	198,385,791,928.82	113,291,463,216.26
1.4.1	Авсан хүү (+)	520,447,996,974.56	331,845,401,178.02
1.4.2	Төлсөн хүү (-)	(271,602,169,302.54)	(188,838,726,423.60)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(46,440,564,183.66)	(29,715,211,538.16)
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	(4,019,471,559.55)	-
1.4.5			
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	146,952,580,944.31	(378,931,040,143.50)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,934,655,240.08	7,199,418,998.91
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	18,744,790.82	1,718,998.87
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого		
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	915,910,449.26	2,096,500,000.05
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө		
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	-	2,851,199,999.99
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	12,000,000,000.00	-
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.10	Бусад мөнгөн орлого	-	2,250,000,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(34,506,166,456.58)	(46,813,486,225.07)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,157,026,883.46	6,115,888,342.10
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,701,939,573.12	697,597,882.97
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	18,926,200,000.00	-
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	40,000,000,000.00
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(0.00)
2.2.9	Бусад мөнгөн зарлага	721,000,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(21,571,511,216.49)	(39,614,067,226.16)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	803,183,143,887.81	406,465,954,737.29
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	769,144,149,067.81	406,465,954,737.29
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	34,038,994,820.00	-
3.1.4	Төрөл бүрийн хандив		
3.1.5	Бусад		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(408,127,346,351.64)	(139,356,124,453.53)
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	378,127,346,351.64	97,248,124,453.53
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн		
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		

3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн		
3.2.5	Төлсөн ногдол ашиг	30,000,000,000.00	42,108,000,000.00
3.2.6	Бусад		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	395,055,797,536.17	267,109,830,283.76
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	520,436,867,263.98	(151,435,277,085.90)
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,277,711,125,330.34	1,798,147,992,594.32
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,798,147,992,594.32	1,646,712,715,508.43

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБАЯР

ХАСBANK ХАСBАНКНЫ ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСНЫ ҮЛДЭГДЛИЙН ТАЙЛАН

2024 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

№	Дансны нэр	Дүн
1	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг	249,669,063,130.3
2	Барьцаа хөрөнгө	5,726,218,914,314.4
3	Тэнцлээс хассан хөрөнгө	104,941,346,193.8
4	Дериватив санхүүгийн хэрэгсэл	1,422,616,591,497.3
5	Харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгө	-
6	Барьцаанд тавьсан хөрөнгө	-
7	Тэнцлийн гадуурх бусад дансууд	347,576,053,667.9
Нийт		7,851,021,968,803.7

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБАЯР